

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
..... оны ... сарын ..... -ний өдрийн  
..... дүгээр тушаалын хавсралт

2020.04.28.

## **ОЙД АРЧИЛГАА, ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Ойд арчилгаа, цэвэрлэгээ /цаашид “арчилгаа, цэвэрлэгээ” гэх/ хийх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Ойн арчилгаа гэдэгт ойн хэвийн өсөлт хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор мод сөөгийг үе шаттайгаар сонгон огтлох арга хэмжээ хамаарна.

1.3. Ойн цэвэрлэгээ гэдэгт Ойн тухай хуулийн 3.1.15-д заасан арга хэмжээ хамаарна.

1.4. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд арчилгаа, цэвэрлэгээ хийхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### **Хоёр. Ойн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг төлөвлөх, хуваарилах**

2.1. Ойн арчилгааг дараах арчилгааны хэлбэр тус бүрээр төлөвлөнө. Үүнд:

2.1.1. Шигүү ургасан зулзаган ойн нэг модонд ногдох гэрлийн хэмжээг нэмэгдүүлж, модны өсөлт, хөгжилтийг түргэтгэх зорилго бүхий гэрэлжүүлэх;

2.1.2. Өсвөр залуу модны байршлыг талбайд жигд болгох, нэг модонд ногдох тэжээлийн талбайг нэмэгдүүлэх зорилго бүхий тохируулах;

2.1.3. Залуу модны титэм, ишний хэлбэрийг сайжруулж, модны өндөр болон бүдүүний өсөлтийг нэмэгдүүлэх тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх зорилго бүхий сийрэгжүүлэх;

2.1.4. Дунд насны модны өсөлтийг түргэтгэж, болцын насыг богиносгох зорилго бүхий завсрын.

2.2. Ойд хийгдэх цэвэрлэгээг дараах ойн цэвэрлэгээний хэлбэр тус бүрээр төлөвлөнө. Үүнд:

2.2.1. Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасны нөлөөгөөр амьдрах чадваргүй унасан, хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг ойгоос гаргах цэвэрлэгээний ажил;

2.2.2. Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж хатсан, цаашид ургах чадваргүй болсон ойн модыг огтлох замаар ойг цэвэрлэх, эрүүлжүүлэхэд чиглэсэн цэвэрлэгээний огтлолт.

2.3. Цэвэрлэгээний огтлолтыг дунд эрчимтэй түймэрт өртсөн болон хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж цаашид ургах чадваргүй ой доторх модыг түүвэрлэн огтлох аргаар;, хүчтэй эрчимтэй түймэрт өртсөн болон иш, холтос, модлогийн хөнөөлт шавжид нэлэнхүйдээ нэрвэгдэж ургах чадваргүй болсон ойд эхний ээлжинд нөөцийн 70 хүртэл хувийн эрчимтэй хийхээр төлөвлөнө.

2.4. Арчилгаа, цэвэрлэгээг төлөвлөхөд хэмжих үндсэн үзүүлэлт нь талбай /га/-аар, дагалдах үзүүлэлт нөөц /м<sup>3</sup>/-өөр байна.

2.5. Сум, дүүргийн Засаг дарга болон Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь дараа жилд ойгоос арчилгаа, цэвэрлэгээнээр бэлтгэх модны саналаа ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн гаргаж, тухайн ойн санг харъяалах сумын болон сум дундын Ойн ангид /цаашид “Ойн анги” гэх/ ирүүлнэ. Ойн анги нь тухайн саналыг ой зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөний төлөвлөлттэй тулган, хянан баталгаажуулж, харъяа аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт тухайн оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.6. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд хэрэгжүүлэх арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг харъяалах аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөнд төлөвлөсний дагуу тухайн тусгай хэрэгцээний газрын эзэмшигч, ашиглагчид мэдэгдсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2.7. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараа жилд өөрийн аймгийн ойн санд хийх арчилгаа, цэвэрлэгээгээр бэлтгэх модны саналаа Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ.

2.8. Ойн тухай хуулийн 28.3, 32.1-д тус тус заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын баримт бичиг, “Ойн менежментийн төлөвлөгөө”-г үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, тусгай хамгаалалттай газар нутаг тус бүрээр дараа жилд хийх арчилгаа, цэвэрлэгээгээр бэлтгэх модны хэмжээг тогтоосон шийдвэр гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад болон Тусгай хамгаалалттай газар нутгийн

хамгаалалтын захиргаанд тухайн жилийн 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.9. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.8-д заасан байгууллагаас тогтоосон хэмжээнд багтаан, Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-д заасны дагуу дараа жилд хийх арчилгаа, цэвэрлэгээний хэмжээг тухайн оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор сум, дүүрэг бүрээр тогтооно.

2.10. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.9-д заасан байгууллагаас тогтоосон хэмжээнд багтаан, Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.2-д заасны дагуу тухайн жилд ойд хийх арчилгаа /энэ журмын 2.1.2, 2.1.3/, цэвэрлэгээний огтлолтын хэмжээг ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах эрх бүхий аж ахуйн нэгж бүрээр, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3-д заасны дагуу иргэдийн ахуйн хэрэглээнд ашиглах модыг баг тус бүрээр тухайн оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тогтооно.

2.11. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь энэ журмын 2.8-д заасан байгууллагаас тогтоосон хэмжээнд багтаан, арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг гүйцэтгэх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдийн дунд зарлаж, тухайн оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор шалгаруулна.

2.12. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь тухайн жилд арчилгаа, цэвэрлэгээгээр мод бэлтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тухайн сумын болон Ойн ангийн төлөөллийг оролцуулан зохион байгуулна.

### **Гурав. Арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг зохион байгуулах**

3.1. Энэ журмын 2.2.2-т заасан ойн цэвэрлэгээний огтлолтыг арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

3.2. Энэ журмын 2.2.1-д заасан ойн цэвэрлэгээний ажлыг арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, иргэн гэрээ байгуулан гүйцэтгэж болно.

3.3. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг гүйцэтгэхээр сонгон шалгарсан ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлтэй тухайн сумыг харъяалсан Ойн ангийг оролцуулан гурвалсан гэрээ байгуулна.

3.4. Сумын болон Улсын тусгай хамгаалалттай газрын ойн менежментийн төлөвлөгөөнд арчилгаа, цэвэрлэгээ хийхээр төлөвлөсөн ойд Ойн анги талбайг тусгаарлах ажлыг гүйцэтгэнэ.

3.5. Мод бэлтгэх талбай тусгаарлах ажлыг арчилгаа, цэвэрлэгээ хийхээс нэг жилийн өмнө ургамал ургалтын хугацаанд /мод ногоорсон үед/ хийж гүйцэтгэнэ.

3.6. Арчилгааны сийрэгжүүлэх, завсрын хэлбэрийн огтлолт болон цэвэрлэгээний огтлолтоор мод бэлтгэх талбай тусгаарлаж, тооллого хийх үед огтлолтонд орох модыг үндэсний хүзүү орчимд тэмдэглэнэ.

3.7. Арчилгаа, цэвэрлэгээ хийхээр талбай тусгаарлах, шон, тэмдэг тавихад ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах стандартыг мөрдөнө.

3.8. Арчилгаа, цэвэрлэгээ хийсэн тухай бүртгэлийг Ойн анги эрхлэн, сум, дүүрэг, Улсын тусгай хамгаалалттай газрын ойн мэдээллийн санд өөрчлөлтийг оруулж хөтөлнө.

3.9. Арчилгаа, цэвэрлэгээгээр мод бэлтгэхэд болон мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажилд холбогдох журам, стандартыг мөрдөж ажиллана.

#### **Дөрөв. Арчилгаа, цэвэрлэгээ хийх иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг**

4.1. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагууд арчилгаа, цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх тохиолдолд Ойн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу мод бэлтгэх гэрээг Ойн ангитай байгуулна.

4.2. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагууд арчилгаа, цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх гэрээ байгуулсаны дараа энэ журмын 3.4-д заасны дагуу талбай тусгаарлах ажлыг тодотгон хийлгэнэ.

4.3. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага арчилгаа, цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх тохиолдолд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг бүрэн төлсний дараа Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу мод бэлтгэх эрхийн бичгийг ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/-аас авсан байна.

4.4. Арчилгаа, цэвэрлэгээ хийхээр гэрээ байгуулсан ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь мод бэлтгэлийн технологийн карт боловсруулж, Ойн ангиар хянуулан, батална.

4.5. Арчилгаа, цэвэрлэгээгээр бэлтгэсэн модыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах тохиолдолд Ойн тухай хуулийн 28.4, 34.4-д заасны дагуу мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг Ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/-аас авсан байна.

4.6. Иргэн зохих зөвшөөрөл авч ойн цэвэрлэгээгээр ахуйн хэрэглээнд зориулан бэлтгэсэн модыг /арилжааны зорилгоор/ бусдад борлуулахыг хориглох бөгөөд мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгохгүй.

4.7. Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага арчилгаа, цэвэрлэгээгээр бэлтгэсэн хэрэглээний модныхоо 100м<sup>3</sup> тутамд 2 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийнэ.

4.8. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийж дууссаны дараа тухайн ой бүхий нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагчид актаар хүлээлгэн өгнө.

#### **Тав. Арчилгаа, цэвэрлэгээнд тавих хяналт**

5.1. Арчилгаа, цэвэрлэгээгээр мод бэлтгэх, тээвэрлэх ажлын явцад Ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч байнгын хяналт тавина.

5.2. Байгаль хамгаалагч мод бэлтгэх гэрээ, технологийн карт, талбай тусгаарлалтын баримт бичиг, мод бэлтгэлийн эрхийн бичиг зэргийг нягтлан шалгасны дараа мод бэлтгэх эхлэлийн акт үйлдэж талбайг хүлээлгэн өгнө.

5.3. Байгаль хамгаалагч мод бэлтгэлийн технологийн картын мөрдөлтөд байнгын хяналт тавина.

5.4. Байгаль хамгаалагч бэлтгэсэн модны тээвэрлэлтэд бүртгэлийн дэвтэр хөтөлж, дээд агуулахаас тээвэрлэж буй модонд хяналтын хуудсаар хяналт тавих бөгөөд тухайн талбайгаас бэлтгэх модны хэмжээнд хүрмэгц ажлыг зогсоож, мод бэлтгэлийн гүйцэтгэлийг шалган, хүлээн авч, мод бэлтгэлийн төгсгөлийн акт үйлдэнэ.

5.5. Байгаль орчны хяналтын улсын байцаагч мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголт, ашиглалт болон мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавина.

5.6. Ойн анги мод бэлтгэлийн технологийн картыг хянаж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавина.

5.7. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, Ойн анги, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх ажлын явцад технологийн хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, журам, зааврыг сурталчилан таниулах, технологийн зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

**Зургаа. Арчилгаа, цэвэрлэгээний гүйцэтгэлийг шалгах, хүлээн авах, тайлагнах**

6.1. Ойн анги арчилгаа, цэвэрлэгээний тайланг энэ журмын 5.4.-д заасан актыг үндэслэн хүлээж авна.

6.2. Арчилгаа, цэвэрлэгээний гүйцэтгэлийг шалган хүлээн авахдаа дараах шалгуурыг баримтлана. Үүнд:

6.2.1. Арчилгаа хийх ойг зөв сонгосон эсэх, ойн өтгөрөл, модны нас, огтлох модны сонголт, гэмтлийн байдал, тооллого, тэмдэглэл, холбогдох журам, стандартад заасантай тохирч байгаа эсэхийг болон талбай тусгаарласан байдлыг шалгаж, ажлын чанарт үнэлгээ өгнө.

6.2.2. Ойн арчилгаа хийсэн нийт талбайн 2 хувиас багагүй талбайд жишиг талбай байгуулж, шалгах тооллого хийж, үлдээсэн модыг зөв сонгосон, модыг хэрэглээ, түлээнд зөв ангилсан, тоолсон эсэхийг шалгана.

6.3. Ойн цэвэрлэгээний гүйцэтгэлийг хүлээж авахдаа ойн экологийн байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй, өсвөр модыг хамгаалах технологийг сонгосон эсэх, үндэсний хүзүү орчимд огтлох тэмдэглэгээ тавьсан модыг огтолсон эсэхийг шалгаж хүлээж авна.

6.4. Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа өөрийн ойн санд хэрэгжүүлсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээний тухайн жилийн тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайлан, мэдээг 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор, жилийн тайлан, мэдээг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор гаргаж, тухайн ойн санг харъяалсан Ойн ангид хүргүүлнэ.

6.5. Ойн анги нь тухайн жилд харъяа сумдынхаа болон Тусгай хамгаалалттай газрын ойн санд хэрэгжүүлсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайлан, мэдээг 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн тайлан, мэдээг дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргаж, холбогдох аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлнэ.

6.6. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь тухайн жилд хийсэн арчилгаа, цэвэрлэгээний тайланг нэгтгэн байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан улсын мэдээллийн санд оруулна.

6.7. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээний гүйцэтгэлийг шалгаж, хүлээн авсан актад үндэслэн эцсийн санхүүжилтийг олгоно.

6.8. Энэ журмын 6.7-д заасан эцсийн санхүүжилтийг олгохдоо арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээний талбайн хэмжээг гэрээнд зааснаас дутуу гүйцэтгэсэн тохиолдолд нормативт зардлыг хувь тэнцүүлэн бууруулж, санхүүжүүлнэ.

### **Долоо. Бусад**

7.1. Арчилгаа, цэвэрлэгээний технологи зөрчсөнтэй холбогдон гарсан гомдол, маргааныг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад маргааныг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

-----oOo---